



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

№ 01

Дархан уул аймаг

**Компанийн 2025 оны санхүүгийн тайлан,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус
гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.3 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.
2. Тус компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Оюунд тус тус үүрэг болгосугай.

Хурлын дарга



Ж.ОЧИРСҮХ



“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

№ 02

Дархан-Уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.7 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2026 оны зардлын төсвийг 15,720,000 төгрөгөөр тогтоосугай.
2. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ОЧИРСҮХ

“Тээвэр Дархан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын цалин /төг/¹	1 жилийн цалин
1	Ердийн гишүүн ТУЗ-н дарга	150000	1800000
2	Ердийн гишүүн	130000	1560000
3	Ердийн гишүүн	130000	1560000
4	Ердийн гишүүн	130000	1560000
5	Ердийн гишүүн	130000	1560000
6	Ердийн гишүүн	130000	1560000
7	Хараат бус гишүүн	130000	1560000
8	Хараат бус гишүүн	130000	1560000
9	Хараат бус гишүүн	130000	1560000
10	Нарийн бичгийн дарга	120000	1440000
	Нийт	1310000	15720000



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

№ 03

Дархан уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Тээвэр Дархан” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.1 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр: 9
 - 1.1.1. М.Жавхлан
 - 1.1.2. М.Оюун
 - 1.1.3. Ж.Мөнхтөр
 - 1.1.4. Л.Амарсанаа
 - 1.1.5. Б.Саруул
 - 1.1.6. Ж.Очирсүх
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Д.Бумцэрэн
 - 1.2.2. Д.Чулуун
 - 1.2.3. С.Бат-Эрдэнэ
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2026 оны 06 дугаар сард багтаан хуралдуулж ТУЗ-ийн дарга, түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын анхны хурлаа зохион байгуулж, ТУЗ-ын дарга сонгох, компанийн засаглалын журам, баримт бичгүүдийг хэлэлцэх, цаашид хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Э.Жавхлантөгс)-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” “Тээвэр Дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04-р сарын 29-ны өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ОЧИРСҮХ



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

№ 04

Дархан уул аймаг

Ногдол ашиг олгох тухай.

“Тээвэр дархан” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 2 сарын 16-ны өдрийн тогтоол, хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4-р сарын 27-ны өдрийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ээлжит хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 500 төгрөгөөр олгосугай.
2. Ногдол ашгийг 2026 оны 12-р сарын 31-ний дотор олгохыг гүйцэтгэх захирал М.Оюунд үүрэг болгосугай.

Хурлын дарга



/ Ж.Очирсүх /